

## Цөмийн хаягдал: Харж сууж ханалаа, хөдөлж ажиллах цаг иржээ...



Сайн байцаана уу?

Та бүхэн голомт.орг дээр өнгөрсөн 3 сарын сүүлчээс эхлэн тавьж буй цөмийн хаягдал, цөмийн аюулын талаарх нийтлэлүүдийг уншсан байх. Тэгвэл өнөөдөр дэлхийн олон улсад тархан суугаа Монголчуудынхаа хүсэл санаачлагаар цөмийн аюулыг эсрэг нэгдэх Фэйсбукийн шинэ бүлгийг нээж байна. Бусад Фэйсбукийн санаачлагуудаас ялгаатай нь гэвэл Anti Nuclear Movement Mongolia нь итгэл үнэмшил нэгтэй хүмүүсийг уулзуулж, тэднийг дуу хоолойгоо олон нийтэд хүргэх, цөмийн аюулыг энгийн тайван замаар эсэргүүцэх идэвхтэй үйл ажиллагааг элдэв улс төржсөн санаачлагаас ангид явуулахад нь иргэдийг дэмжих зорилготой болно.

Эх орондоо цөмийн хаягдал булшлах бас үйлдвэрлэн бий болгохын эсрэг үзэлтэй, цөмийн хор хөнөөлийн илүү ихийг сурч мэдэх сонирхолтой төдийгүй энэ талаар олон нийтэд сурталчлах, цөмийн эсрэг дуугаа өргөх үйлсийг зохион байгуулахад гар бие оролцох чин хүсэлтэй эх оронч Монголчуудыг урьж байна.

Та бүхнийг хүндэтгэсэн,

Амарлин ([amarlin06@gmail.com](mailto:amarlin06@gmail.com))